



БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД МОНГОЛ АРДЫН ТОГЛООМЫН НӨЛӨӨ

Т.Гэрэлтуяа, доктор
МУБИС-ийн СӨБСС-ийн Сурган хүмүүжүүлэх ухаан,
сэтгэл судлалын тэнхимийн багш

Abstract: Mongolians have rich experiences of teaching approaches to support child development and learning. Traditionally, the main living practice was to herd animals, so children used to play with wood, rope, stones and ankles. Today, this playing practice can be a great support for restoring traditional plays, therefore, preschool teachers and adults should let and support child play. Thus, this comparative research aimed at identifying how many alternatives of play for children can be provided through preschool education. The findings proved that these traditional plays could be developmentally appropriate with the principles of child learning drawn in the “The Policy of Early Childhood Education”, the 327th order, approved on August 23, 2013 by the Minister of Education, Culture and Science of Mongolia.

Түлхүүр үг: Хүүхэд, гогдоо наадам, оньсон тоглоом, шагайн наадам

Монгол тоглоом наадам бол монгол үндэсний бие, хэл, сэтгэлээрээ туурвиж хөгжүүлсэн хэдэн мянган тоглоом наадмын тогтолцоо, ардын билиг зүйн гоц төрөл нь юм.

То вангийн сургаалд:

“Хүүхдийг идэж чадмагц баруун гарыг сургана

Явж чадмагц дөрвөн зүг, дээд доодыг ухуулна

Мэхэсхийж чадмагц ёслол, найр тавих, эцэг эхээ хүндэтгэхийг сургана” хэмээн өгүүлсэн нь хүүхдийг бага гэлгүйгээр хөдөлмөрт сургаж ардын ёс заншилаас

эзэмшүүлэхийг чухалчилсан нь тэдний цаашдын хөгжилд эерэгээр нөлөөлөхийн ач холбогдлыг тодорхойлсны илрэл юм.

Монгол тоглоомын хөгжил, зүй тогтолыг Д.Болдбаатар, П.Сүхбаатар нар дараах байдлаар ач холбогдолыг нь тодорхойлсон байна.

I. Хүүхдэд монгол сэтгэлгээг төлөвшүүлнэ.

II. Хүүхдэд хүн болох ухааны цагаан толгойн хичээл, алс ирээдүйн чиг баримжааг тогтоох хэрэглүүр болно.

III. Хүүхдийн төрөлх авьяас, нуугдмал удамшилыг илрүүлэх, маргаашийнх нь хувь тавилангийн бэлтгэл юм.

IV. Хүүхдийн танин мэдэхүйн таван эрхтнийг /үнэрлэх, амтлах, харах, сонсох, мэдрэх/ хөгжүүлэх, хорвоог танин мэдэх хүслийг улам илүү нэмэгдүүлэх, халах, хөрөх, өвдөх, баясах, гутахыг мэдэх сургамж болж өгдөг.

Хүүхдийн зохион бүтээх, эвдэх сүйтгэх, даван туулах, бултах, эвийг олох, өөрийгөө хамгаалах ухаан нь өөрөө болоод үе тэнгийнхэнээсээ албадлагагүйгээр суралцах онцгой хэлбэр болдог. (Сүхбат, Нарантуяа, Өлзийсайхан, 2010, х.58)

“Монгол ардын үндэсний тоглоом, наадам нь өөрийн гэсэн зорилготой бас хүүхдэд үл ажиглагдам үлдэц сайтай байдаг. Тоглоом нь хүүхдийг шууд ба шууд бус зорилгоор хөгжүүлнэ. Монгол ардын үндэсний тоглоом, наадам нь үнэ өртөг багатай, хэрэглэхэд хялбархан сурган

хүмүүжүүлэх ач холбогдолтой ихтэй юм” (Үдэрпил, 1987).

Монгол ардын зүйр цэцэн үгэнд “Хүнийг шинжье гэвэл нөхрийг нь, хүүхдийг шинжье гэвэл тоглоомыг нь шинж” гэсэн байдаг. Энэ нь бага насны хүүхэд нэг бүрийн тоглох тоглоомын онцлог, мөн чанар, сурган хүмүүжүүлэх ач холбогдлыг тодруулж өгдгөөрөө онцлогтой юм. Монголчууд өвөг дээдсээсээ уламжлан ирсэн ардын үндэсний тоглоом, наадмыг дараах байдлаар ангилсан байдаг.

Бүдүүвч 1

Монгол ардын тоглоомын төрөл ангилал




Цэцэрлэгийн 4-5 хүртэл насны хүүхдийг хөгжүүлэхэд “Тогдоо наадам”, “Шагайн тоглоом”, “Турамсан” оньсон тоглоомнууд хэрхэн нөлөөлдгийг тодруулах зорилгоор дараах үзүүлэлтийн дагуу судалгааг авч үр дүнг тооцсон болно.

“Тогдоо наадам”

1. Гар хурууны хөдөлгөөний эвсэл
2. Юмсыг бодитоор болон хийсвэрлэх чадвар
3. Гартаа утсаа зөв эргүүлэх хийх чадвар
4. Гарнаас утсыг зөв авч байгаа эсэх
5. Бүтээсэн зүйлээ зөв нэрлэж байгаа эсэх


Зураг 1.



“Турамсан” оньсон тоглоом

1. Мод тус бүрийг зөв байрлуулан барих чадвар
2. Хоёр модыг зөв байрлуулж дараагийн модыг зөв угсарч байгаа эсэх
3. Гурван модыг зөв байрлуулан, углуурыг зөв оруулах чадвар
4. Дарааллын дагуу модыг задалж байгаа эсэх

Зураг 2



“Шагайн тоглоом” тоглоом

1. Шагайны дөрвөн талыг зөв нэрлэж байгаа эсэх
2. Шагайг олбогоос илүү гаргахгүйгээр орхиж байгаа эсэх
3. Авхаалж гарган дөрвөн бэрхийг түрүүлэн авч байгаа байдал
4. Шагайг онож нясалж байгаа чадвар
5. Авсан шагайгаа хишиг уутандаа хийж байгаа эсэх

Зураг 3





Хүснэгт 1

Судалгаанд хамрагдсан хүүхдийн хүйсийн байдал

№	Дүүрэг, хүүхдийн тоо	Хүүхдийн тоо	Шагайн тоглоом		Онъсон тоглоом		Гогдоо наадам	
			Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
1	БЗД-ийн “Ягаан цамхаг” цэцэрлэг	10	5	5	5	5	5	5
2	СБД-ийн 69-р цэцэрлэг	10	5	5	5	5	5	5
3	СХД-ийн 119-р цэцэрлэг	10	5	5	5	5	5	5
4	ЧД-ийн 108-р цэцэрлэг	10	5	5	5	5	5	5
	Нийт хүүхдийн тоо	40	20	20	20	20	20	20

Цэцэрлэг бүрээс оролцсон хүүхдүүдийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдсан хүүхдийн оролцоог ажиглан тэмдэглэл хөтөлснөөс гадна, авсан оноогоор нь хувьчлан үр дүнг тооцсон болно.

Хүснэгт 2

А. “Тогдоо наадам”

№	Нэр	Зааж өгсөн арга	Зааж өгсөн давталт	Хийж байгаа явцыг ажигласан тэмдэглэл
1	Б.Б /4 нас бсар/	1. Биечлэн хийж үзүүлэх арга 2. Тайлбарлан таниулах арга 3. Ярилцлагын арга 4. Ганцаарчлан ажиллах арга	2	Ажиглаж байх хугацаанд хүүхэд эхний удаад аль утсыг нь татахаа мэдэхгүй эргэлзэж байсан. Гэвч дараа нь бага багаар олон удаа давтаж хийснээр сайн сурсан.

Хүснэгт 3

Б. “Онъсон тоглоом”

№	Нэр	Зааж өгсөн арга	Хүүхдийн гүйцэтгэсэн хугацаа	Хийж байгаа явцыг ажигласан тэмдэглэл
1	Б.Т /4 нас 10 сар/	1. Биечлэн хийж үзүүлэх арга 2. Тайлбарлан таниулах арга 3. Ярилцлагын арга 4. Ганцаарчлан ажиллах арга	1’25”	Хүүхэд наадгайг сайн ажиглан гурван модыг зөв байрлуулан, углуурыг оруулахдаа бага зэрэг саатсан хэдий ч угсарч чадсан.

Хүснэгт 4

В. “Шагай няслах” тоглоом

№	Нэр	Зааж өгсөн арга	Хүүхдийн гүйцэтгэсэн хугацаа	Хийж байгаа явцыг ажигласан тэмдэглэл
1	Т.А /4 нас 7сар/	1. Биечлэн хийж үзүүлэх арга 2. Тайлбарлан таниулах арга 3. Ярилцлагын арга 4. Ганцаарчлан ажиллах арга	2	Бусад ардын тоглоомноос өмнө нь хэд хэдэн удаа шагайг харж байсан учир би тоглох сонирхолтой байна гэж ярьсан. Хүүхэд эхлээд шагайны 4 талыг нэрлэж чадахгүй байсан. Гэхдээ шагайг олбогноос гаргахгүй зөөлөн орхисон. Шагайг маш гярхай харж зөв нясалсан. Няслахдаа эрхий, долоовор хурууны няслалт хийсэн. 30 минут хамтран тоглосны дараа бусад хүүхдүүддээ зааж өгч байлаа.


Хүснэгт 5

Судалгаанд хамрагдсан хүүхдийн оролцоог цэцэрлэг нэг бүрээр харуулбал;

№	Цэцэрлэг	Хүүхдийн тоо	Шагайн тоглоом	Гогдоо тоглоом	Онъсон тоглоом
1	БЗД-ийн “Ягаан цамхаг” цэцэрлэг	10	84,5%	34%	59%
2	СБД-ийн 69-р цэцэрлэг	10	92%	25%	57%
3	СХД-ийн 119-р цэцэрлэг	10	87%	32%	62%
4	ЧД-ийн 108-р цэцэрлэг	10	75,5%	29%	50%

Диаграмм 1

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн оролцоог цэцэрлэг нэг бүрээр гарган харуулахад



Судалгаанд 4 дүүргийн 4 цэцэрлэгийн хүүхдийн оролцоог нэгтгэн үзлээ. Шагайн тоглоомоор хүүхдийн тоглох чадвар бусад тоглоомын төрлөөсөө илүү хувьтай байна. Бүлгүүдэд нь шагай түлхүү байдаг харин гогдоо болон онъсон тоглоом тэр бүр байдаггүй тул хүүхдүүд ихэд сонирхон оролцож байсан хэдий ч чадахгүй тохиолдолд өөр тоглоомоор тоглоё чадахгүй байна гэх зэргээр анхаарлаа өөр тоглоомд шилжүүлж байлаа. Багш болон насанд хүрэгчид хэт удаан хугацаагаар биш хүүхдийнхээ онцлог, хэрэгцээнд нь тулгуурлан алгуурхан тоглоомыг тоглох аргачлалыг зааж өгөх шаардлагатай.

ДҮГНЭЛТ

1. Монголчууд бид бүхэн үндэснийхээ өв соёл, ёс заншлаа хадгалан авч үлдэхийн тулд тоглоом, наадгайн төрөл ангилал, ач холбогдлыг сайтар мэдэж, үр хүүхэддээ зааж өгч байх нь зүйтэй байна.
2. Монгол үндэсний тоглоом нь агуу баялаг бөгөөд тоглоход авсаархан, үнэ өртөг шаарддаггүй, ямар ч насны хүний оюун ухаан-танин мэдэхүй, авхаалж самбааг хөгжүүлэх сайн талтай тул бид бүхэн хойч үедээ уламжлуулан үлдээх нь зүй ёсны хэрэг юм.
3. Монгол ардын тоглоом, наадгай бүр нь тодорхой дүрэм, зааврын дагуу тоглогддог учир хүүхдэд бага наснаас нь зааж өгвөл тэд сургуульд элсэн орсноор дүрэм, журмыг баримталдаг чадварт суралцах бүрэн боломжтой.
4. Хүүхдийг монгол ардын үндэсний тоглоомоор тоглож байгаа явцыг харахад “Шагайн тоглоом”-оор тоглох чадвар нь илүү сайн 75,5-92%-тай байна. Энэ нь өнөөдөр хүүхдийн цэцэрлэгт тэднийг үндэсний шагайн тоглоомоос өөр ардын тоглоом наадгайгаар тоглуудаггүйн илрэл юм.



5. Цэцэрлэгийн багш, эцэг эхчүүд бид бүхэн өөрсдөө ардын тоглоомыг тоглох аргачлалын сайтар сурч “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлэхийг чухалчлах шаардлагатай юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Балхаажав, Ц. (2001). *Хүүхэд*. Монгол: “Мөнхийн үсэг” ХХК

Гэрэлтуяа, Т. (2012). *Хүүхдийн хөгжилд шагайн тоглоомын үзүүлэх нөлөө*. Монгол: “Сэлэнгэ пресс” ХХК.

Сүхбат, Ц., Нарантуяа, Т., Өлзийсайхан, С. (2012). *Монгол тоглоом*. Монгол: Урлах Эрдэм

Түмэн-Өлзий, Ц. (2011). *Онъсон тоглоом*. Монгол: ARILDAL

Үдэрпил, Ц. (1987). *Монгол ардын тоглоомын сурган хүмүүжүүлэх ач холбогдол* Монгол: Монгол хэвлэл